

Сонгосон ТЕЗ нарын зарим хөтөлбөрийн ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйгээр боловсруулсан 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжийн хавсралт

Төсвийн байгууллагад зориулсан төсвийн шалгах хуудас

[Энэхүү төсвийн шалгах хуудас нь ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөвлөлтийн удирдамжийн нэг хэсэг бөгөөд төсвийн төсөл боловсруулахад төсвийн байгууллага өөрөө өөрийгөө шалгах байдлаар хэрэглэнэ.]

1. ТШЗ-ийн төсвийн төслийг шалгах хуудас
2. ТТЗ-ийн төсвийн төслийг шалгах хуудас
3. ТЕЗ-ийн төсвийн төслийг шалгах хуудас

1.ТШЗ-ийн төсвийн төслийг шалгах хуудас

№	Асуулт	Тийм ✓ Үгүй x	Тайлбар
1	Төсвийн саналыг ажлын хэсгийн хүрээнд боловсруулсан эсэх?		
2	Тухайн аймаг/нийслэлийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөл болон холбогдох нөхцөл байдлын шинжилгээнд ¹ үндэслэн төсвийн саналыг боловсруулсан эсэх?		
3	Холбогдох оролцогч талуудтай төсвийн саналын хэлэлцүүлэг өрнүүлж, хэлэлцүүлгийн саналыг тусгасан эсэх?		
4	Тухайн орон нутагт хэрэгжих орон нутгийн төсөв болон бусад санхүүжилтийн эх үүсвэр бүхий үйл ажиллагаа, арга хэмжээтэй давхцаагүй эсэх? <i>Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдаж байгаа бол тухайн үйл ажиллагаанаас өөр давхцаагүй үйл ажиллагаанд төсөв хуваарилна.</i>		
5	Хөтөлбөрийн үр дүнгийн суурь болон зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийг тооцохдоо шалгуур үзүүлэлтийн тайлбар хүснэгттэй нарийвчлан танилцсан эсэх?		
6	Хөтөлбөрийн үр дүн болон үйл ажиллагааны үзүүлэлт нь 2024,2025, 2026 онуудад тус тус хүрэхүйц бодитоор тодорхойлогдсон эсэх?		
7	Шалгуур үзүүлэлт нь SMART зарчмын дагуу тодорхойлогдсон эсэх? <i>(S-Тодорхой, M-Хэмжигдэхүйц, A-Бодитой, R-Хамааралтай, T-Цаг хугацаатай)</i>		
8	Үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх шинэлэг арга замыг төсвийн саналд тусгасан эсэх? <i>(Өнгөрсөн 3-5 жилийн бодлого, төсвийн шинжилгээ хийж, үр ашиггүй байгаа үйл ажиллагаа, арга хэмжээг сольж хэрэгжүүлэх шаардлагатай.)</i>		
9	Хөтөлбөрийн үр дүнд хувь нэмэр оруулж буйгаар нь үйл ажиллагааг эрэмбэлсэн эсэх? <i>Хүрэх үр дүнд хамгийн их ач холбогдолтой, хувь нэмэр оруулж байгаагаар нь эрэмбэлж төсөв тооцно.</i>		
10	Үйл ажиллагааны төсвийг бодлогын эрэмбийн дагуу хуваарилсан эсэх? <i>(Хүрэх үр дүнд хамгийн их хувь нэмэр оруулж буй үйл ажиллагаа/гарцад (орон нутгийн төсвийн санхүүжилтийг харгалзан) төсвийг түлхүү хуваарилна.)</i>		
11	Өнгөрсөн жилүүдийн төсөв зарцуулалт хангалтгүй байсан үйл ажиллагааны төсвийг бууруулах, ач холбогдол бүхий шинэ үйл ажиллагаанд төсөв хуваарилсан эсэх?		
12	ТШЗ-ын нийт төсвийн санал хуваарилагдсан төсвийн хязгаарт багтсан эсэх?		
13	ТТЗ/ТЕЗ-тай хөтөлбөрийн болон үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг зөвшилцсөн эсэх?		

¹ Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 2.4 дүгээр заалт.

2. ТТЗ-ийн төсвийн төслийг шалгах хуудас

№	Асуулт	Тийм ✓ Үгүй ×	Тайлбар
1	ТШЗ-ийн бэлтгэсэн үйл ажиллагааны төсвийн маягыг нэгтгэж тохируулахдаа хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагааны логик холбоог шалгасан эсэх?		
2	ТШЗ нарын тодорхойлсон үр дүн ТЕЗ-ийн тодорхойлсон үр дүнтэй нийцэж буй эсэх?		
3	ТШЗ нарын хөтөлбөр болон үйл ажиллагааны үр дүнгийн саналыг тусгаж холбогдох үр дүнгийн тохируулга хийж, зөвшилцсөн эсэх?		
4	Хөтөлбөрийн үр дүнг хангах үйл ажиллагаануудыг үр дүнтэй, үр ашигтай байдлаар эрэмбэлсэн эсэх?		
5	Хөтөлбөрийн төсвийн хуваарилалтыг оновчтой хийх, үр дүнг сайжруулах санал боловсруулсан эсэх?		
6	Хөтөлбөрийн үр ашгийг сайжруулах, хэмнэлт хийх санал боловсруулсан эсэх?		
7	Хөтөлбөрийн үр дүнг хангахын тулд төсвийн хязгаараас давсан санал боловсруулсан уу? <i>Хэрвээ төсвийн хязгаараас давсан бол энэхүү шалгах хуудасны 3,4,5 заасан ажлыг заавал хийнэ.</i>		
8	Өнгөрсөн хугацааны хөтөлбөрийн болон үйл ажиллагааны санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл дээр дүн шинжилгээ хийж, төсвийн нэгтгэлийг хийсэн эсэх?		
9	Өнгөрсөн 3 жилийн хугацаанд батлагдсан төсвөө бүрэн зарцуулагдаагүй үйл ажиллагаа, хөтөлбөрийн шалтгааныг тодорхойлж, энэ жилийн төсвийн төсөлд сайжруулж тусгасан эсэх?		
10	Хөтөлбөрийн төсвийн төсөлд урсгал, хөрөнгийн зардлаар тооцсон эсэх?		
11	Шалгуур үзүүлэлт нь SMART зарчмын дагуу тодорхойлогдсон эсэх? <i>(S-Тодорхой, M-Хэмжигдэхүйц, A-Бодитой, R-Хамааралтай, T-Цаг хугацаатай)</i>		

3. ТЕЗ-ийн төсвийн төслийг шалгах хуудас

	Асуулт	✓ x	Тайлбар
1	Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлохдоо холбогдох нөхцөл байдлын шинжилгээ, өнгөрсөн 3-5 жилийн гүйцэтгэлийн мэдээлэл дээр үндэслэсэн эсэх?	✓	
2	Хөтөлбөрийн үр дүнг холбогдох хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан эсэх?		
3	Хөтөлбөрийн үр дүнг хэмжих нэг гол гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон эсэх?		
4	Шалгуур үзүүлэлт нь SMART зарчмын дагуу тодорхойлогдсон эсэх? (S-Тодорхой, M-Хэмжигдэхүйц, A-Бодитой, R-Хамааралтай, T-Цаг хугацаатай)		
5	ТЕЗ нь харьяа байгууллагуудын хөтөлбөрийн үр дүнд оруулах хувь нэмрийг зөвшилцөж, тохирсон эсэх?		
6	Хөтөлбөрийн үр дүнгийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд логик холбоотой эсэх?		
7	Төсвийн үр ашигтай байдлын шинжилгээ хийгдсэн эсэх		
8	Хөтөлбөрийн дунд хугацааны үр дүнгийн үзүүлэлт болон бусад нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн дунд хугацааны төсвийн төсөөллийн саналыг боловсруулсан эсэх?		
9	Төсвийн төсөл, төсөөлөл нь төсвийн бодлоготой нийцэж байгаа эсэх?		
10	Хөтөлбөрүүдийн шинж чанар, зорилтот бүлгийн хувьд ижил төстэй үйлчилгээ, үйл ажиллагааг тодорхойлж сайжруулан хэмнэлт хийсэн эсэх?		
11	Хөтөлбөрийн үр дүнг хангахад чиглэсэн шинэ үйл ажиллагаа/арга хэмжээ тодорхойлогдож байгаа бол нэгжийн өртөг тооцох маягтад холбогдох тооцоог хийсэн эсэх?		
12	ТТЗ-аас ирүүлсэн хөтөлбөрийн үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх боломж, судалгааг нэгтгэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд тусгасан эсэх?		
13	Төсвийн тухай хуулийн Хавсралт 1-д хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг төсвийн жилийн хугацаанд биелэгдэхүйцээр тодорхойлсон эсэх?		
14	Төсвийн төсөл 2024 оны төсвийн хязгаарт багтсан эсэх?		